



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА



Улаанбаатар хот

2023



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:

Ашигт малтмал, газрын тосны газрын

Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн

Д.Бадамгарав

Ашигт малтмал, газрын тосны газар
Монгол Улс, Улаанбаатар хот 15170,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,
Засгийн газрын XII байр, Баруун жигүүр
Утас: 976-51-263920

Цахим шуудан: info@mrpam.gov.mn

Цахим хаяг: mrpam.gov.mn

АГУУЛГА

1. УДИРТГАЛ.....	6
1.1. Судалгааны хамрах хүрээ.....	6
1.2. Судалгааны арга.....	8
1.2.1. Судалгааны асуулт.....	8
2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН.....	10
3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	13
3.1. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал.....	13
3.2. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал.....	14
3.3. Улс төрийн тогтвортой байдал.....	15
3.4. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	16
3.5. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	17
3.6. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал.....	19
3.7. Уул уурхайн салбарын татварын орчин.....	20
3.8. Дэд бүтцийн хөгжил.....	21
3.9. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх.....	22
3.10. Амьдрах орчны аюулгүй байдал.....	23
3.11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал.....	24
3.12. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө.....	25
3.13. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	27
3.14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж.....	28
3.15. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	29
3.16. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал.....	30
3.17. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага.....	32
3.18. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал.....	33
3.19. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар.....	34
3.20. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж.....	35
4. ДҮГНЭЛТ.....	37
5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйл ажиллагааны чиглэл	6
Зураг 2. Хөрөнгө оруулалт авсан хэлбэр	7
Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил	7
Зураг 4. Ашигт малтмалын төрөл.....	8
Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ.....	12
Зураг 6. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ.....	13
Зураг 7. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах санал	14
Зураг 8. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлын үнэлгээ.....	14
Зураг 9. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлыг сайжруулах санал	15
Зураг 10. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ.....	15
Зураг 11. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал	16
Зураг 12. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал.....	16
Зураг 13. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчныг сайжруулах санал	17
Зураг 14. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал	18
Зураг 15. Байгаль орчны хууль эрхзүйн орчныг сайжруулах санал.....	18
Зураг 16. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал.....	19
Зураг 17. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах санал	19
Зураг 18. Уул уурхайн салбарын татварын орчин.....	20
Зураг 19. Уул уурхайн салбарын татварын орчныг сайжруулах санал	21
Зураг 20. Дэд бүтцийн хөгжил	21
Зураг 21. Дэд бүтцийг хөгжүүлэх санал	22
Зураг 22. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх	22
Зураг 23. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхыг сайжруулах санал	23
Зураг 24. Амьдрах орчны аюулгүй байдал.....	23
Зураг 25. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал.....	24
Зураг 26. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал.....	24
Зураг 27. Газрын харилцаа, түүний зохицуулалтыг сайжруулах санал	25
Зураг 28. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө	26


Зураг 29. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах төрийн бодлогод оруулах санал.....	26
Зураг 30. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа.....	27
Зураг 31. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал.....	28
Зураг 32. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ	28
Зураг 33. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал.....	29
Зураг 34. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ.....	30
Зураг 35. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал	30
Зураг 36. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдлын үнэлгээ	31
Зураг 37. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах ажиллагааг хялбаршуулах санал	31
Зураг 38. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ	32
Зураг 39. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагыг сайжруулах санал	33
Зураг 40. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдлын үнэлгээ	33
Зураг 41. Уул уурхайн салбарыг авлигаас ангид байлгах санал.....	34
Зураг 42. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын үнэлгээ.....	34
Зураг 43. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах санал.....	35
Зураг 44. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийн үнэлгээ.....	36
Зураг 45. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал	36

1. УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах

1.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ


Хөрөнгө оруулалтын орчны судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг чиглэл тус бүрийн байгууллагуудыг хамруулахыг зорьсон бөгөөд нийт 674 байгууллага хамрагдсан.



Зураг 1. Үйл ажиллагааны чиглэл


Судалгаанд оролцсон байгууллагуудаас ашигт малтмалын геологийн эрэл, хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 81.3% нь байсан бол баяжуулалт, боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, өрөмдлөг тэсэлгээ, хөрөнгө оруулалт болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 18.7%-ийг бүрдүүлсэн.

Дээрх байгууллагуудын хөрөнгө оруулалт оруулсан байдлыг авч үзвэл 63.2% буюу ихэнх нь өөрийн хөрөнгийг төсөлдөө зарцуулсан бол 22% нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж, 8.2% нь банк санхүүгийн байгууллагаас зээл авч, 6.7% нь хөрөнгийн зах зээл, төрийн хөрөнгө оруулалт, бонд, өрийн бичиг, концесс, гэрээ болон бусад байдлаар хөрөнгө оруулжээ.




Зураг 2. Хөрөнгө оруулалт авсан хэлбэр

Үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд байгуулагдаад удаагүй буюу 1-ээс 3 жил болж байгаа аж ахуйн нэгж 19.6%, 4-өөс 6 жил болж байгаа компаниуд 21.5%, 7-оос 10 жил болж байгаа аж ахуйн нэгж 23.3%-ийг эзэлж, 11-ээс 14 жил аж ахуй эрхэлж буй байгууллагууд 18.0%, 15-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагажсан байгууллагууд 17.7%-ийг тус тус бүрдүүлсэн байна.



Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил



Зураг 4. Ашигт малтмалын төрөл

Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн их хувь буюу 35.9%-ийг эзэлж, нүүрсний уурхай 17.2%, хайлуур жоншны уурхай 14.8%-ийг бүрдүүлсэн. Үлдсэн хэсгийг нь төмөр, барилгын материал, гянтболд, зэс, цайр, хар тугалга болон бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүрдүүлсэн байна.

1.2. СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны ажлыг асуулгын аргаар авч, хөрөнгө оруулалтын орчны чиглэлийн асуултуудад үнэлгээ өгөх байдлаар хариултуудыг авч тухайн асуудлыг сайжруулах арга замын талаар санал авлаа.

1.2.1. Судалгааны асуулт

Судалгааны асуулга нийтдээ 27 асуулттай бөгөөд үүнээс 5 асуулт нь ерөнхий мэдээлэл авах асуулт, үлдсэн 22 нь үндсэн асуулт байсан. Үндсэн асуултуудаас 20 асуулт нь уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд үнэлгээ өгөх хариулт болон сайжруулах саналыг авсан бол 1 асуулт нь өмнөх асуултуудад ороогүй чиглэл байвал санал өгч болохоор, 1 асуулт нь энэхүү судалгааны ажлыг цаашид сайжруулахад юу хийх талаар санал авахаар зохиогдсон. Асуултуудыг боловсруулахдаа олон улсад уул уурхайн салбарын хөрөнгө

оруулалтын орчныг үнэлэхэд хэрэглэдэг үзүүлэлт болон манай орны нөхцөл байдалд тохируулсан асуултыг бэлтгэсэн болно.

Хөрөнгө оруулалтын орчныг үнэлж өгч, сайжруулах санал өгөх асуултууд:

1. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал
2. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал
3. Улс төрийн тогтвортой байдал
4. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал
5. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал
6. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал
7. Уул уурхайн салбарын татварын орчин
8. Дэд бүтцийн хөгжил
9. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх
10. Амьдрах орчны аюулгүй байдал
11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал
12. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө
13. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа
14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж
15. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа
16. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал
17. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага
18. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал
19. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар
20. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж

Санал асуулгад оролцогч нь дээрх 20 үзүүлэлт тус бүрт өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй одоогийн байдлыг бодолцон үзэж дараах 5 хариултын аль нэгийг сонгож үнэлэлт өгөхөөр зохицуулсан.

1. Маш муу
2. Муу
3. Дунд зэрэг
4. Сайн
5. Маш сайн

Асуулгын хариултыг геологи, уул уурхайн мэдээллийн системээр дамжуулан хүлээн авсан.

2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд 100 хүртэлх оноогоор үнэлэлт өгсөн. Судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хариултыг үнэлгээ тус бүрийн хувийн жинг гаргаж, жигнэсэн дундаж гаргах байдлаар тооцоолж нэгдсэн үнэлгээг тодорхойлсон.

Үнэлгээний 5 ангилал нь 100 онооны системд дараах онооны хамааралтай байхаар тооцоолсон.

- маш муу үнэлгээ нь 34 хүртэл оноо,
- муу үнэлгээ нь 34-өөс 50 оноо,
- дунд үнэлгээ нь 50-аас 66 оноо,
- сайн үнэлгээ нь 66-аас 84 оноо,
- маш сайн үнэлгээ нь 84-өөс дээш оноо

2023 оны хувьд нэгдсэн дүнгээр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин **52.5** оноо авч **“Дунд”** гэсэн дүнтэй гарсан байна. Судалгааны асуултуудаас маш сайн, сайн, маш муу үзүүлэлттэй асуулт гараагүй бөгөөд дунд ангилалд 12 үзүүлэлт, муу ангилалд 8 үзүүлэлт хамрагдав.

Дунд ангилалд өндөр оноо авсан нь Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал /59.7 оноо/, Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал /58.4 оноо/, Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар /57.7 оноо/ байсан бол Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /56.4 оноо/, Амьдрах орчны аюулгүй байдал /55.1 оноо/, гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх /53.8 оноо/, Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /53.6 оноо/ Уул уурхайн салбарын татварын орчин /53.2 оноо/, Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /53.1 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /52.8 оноо/, Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал /52.8 оноо/, Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /52.4 оноо/ гэсэн асуултууд нь дунд ангилалдаа доогуур жагсжээ.

Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /45.3 оноо/ бол үүний дараа Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага /47.4 оноо/ орсон. Дараагийн

түвшний тааруухан үзүүлэлт нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /48.3 оноо/, Дэд бүтцийн хөгжил /48.4 оноо/, Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /48.9 оноо/ байсан бол муу ангилал дотроо дээгүүр үзүүлэлттэй байгаа нь Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө /49.9 оноо/, Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж /51.4 оноо/, Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал /51.5 оноо/ байв.




Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ

3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД


3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЛИЙГ ОЛЖ АВАХ БОЛОМЖ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал “Дунд” буюу 58.4% байна. Нийт судалгаанд оролцогсдын 53.7% нь дунд зэрэг, 18.8% нь сайн, 16.2% нь муу, 8.3% нь маш муу, 3.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 6. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1055 сайжруулах санал хүсэлтээс харахад 446 санал буюу 42.3% нь цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох, 332 санал буюу 31.5% нь мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах, 235 санал буюу 22.3% нь нээлттэй, ил тод болгох саналыг ирүүлжээ.



Зураг 7. Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах санал

3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, ТЭДГЭЭРИЙН ҮНЭМШИЛТЭЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологи, хайгуулын ажлын үнэмшил “Дунд” буюу 59.7% байна. Нийт судалгаанд оролцогсдын 56.2% нь дунд зэрэг, 23.0% нь сайн, 11.7% нь муу, 7.7% нь маш муу, 1.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 8. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1078 сайжруулах санал хүсэлтээс харахад 283 санал буюу 26.3% нь хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх, 251 санал буюу 23.3% нь ажил хийх боломжийг хангах, хөрөнгө санхүүгээр дэмжих, 162 санал буюу 15.0% нь мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх, 152 санал буюу 14.1% нь


мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, 151 санал буюу 14.0% нь сургалт, гарын авлага, стандарт бий болгох, 79 санал буюу 7.3% нь ил тод, нээлттэй болгох саналыг ирүүлжээ.



Зураг 9. Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдлыг сайжруулах санал

3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ “Муу” буюу 45.3% байна. Нийт судалгаанд оролцогсдын 41.1% нь дунд зэрэг, 27.4% нь муу, 26.1% нь маш муу, 4.3% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 10. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1031 сайжруулах санал хүсэлтээс харахад 276 санал буюу 26.8% нь бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, 225 санал буюу 21.8% нь салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах, 165 санал буюу 16.0% нь удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, тогтвортой ажиллуулах, 159 санал буюу


15.4% нь тогтолцоог өөрчлөх, 103 санал буюу 10.0% нь ЗГ, төрийн байгууллага тогтвортой байх, 42 санал буюу 4.1% нь улс төрчдийн хариуцлагыг сайжруулах, 39 санал буюу 3.8% нь хууль хэрэгжүүлэх саналыг ирүүлжээ.



Зураг 11. Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал

3.4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдлын үнэлгээ “Дунд” буюу 52.4% байна. Нийт судалгаанд оролцогсдын 55.9% нь дунд зэрэг, 21.2% нь муу, 13.5% нь маш муу, 8.3% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 12. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 681 сайжруулах санал хүсэлтээс харахад 196 санал буюу 28.8% нь батлагдсан хуулийг сурталчлан таниулах, сайн хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, 154 санал буюу 22.6% нь мэргэжлийн судалгаа, хүмүүсийн саналыг авах, 143 санал буюу 21.0% нь багасгах, хялбаршуулах, бодит байдалтай уялдуулах, 115 санал буюу 16.9% нь хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, 45 санал буюу 6.6% нь тодорхой, ойлгомжтой болгох, 28 санал буюу 4.1% нь олон улсын жишиг судлах саналыг ирүүлжээ.



Зураг 13. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчныг сайжруулах санал

3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд байгаль орчны хууль эрх зүйн орчны ойлгомжтой байдлын үнэлгээ “Дунд” буюу 56.4% байна. Нийт судалгаанд оролцогсод муу үнэлгээ өгөөгүй бөгөөд 65.3% нь дунд зэрэг, 18.2% нь маш муу, 14.7% нь сайн, 1.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 14. Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1404 сайжруулах санал хүсэлтээс харахад 325 санал буюу 23.1% нь орон нутгийн оролцоог багасгах, 212 санал буюу 15.1% нь оновчтой, тодорхой болгох, 201 санал буюу 14.3% нь ААН-үүдээс ирүүлсэн туршлага, саналд үндэслэн хууль дүрмээ сайжруулах, 178 санал буюу 12.7% нь хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох, 168 санал буюу 12.0% нь хуулиа хэрэгжүүлдэг, хариуцлагатай байх, 125 санал буюу 8.9% нь нөхөн сэргээлтэд анхаарах, 104 санал буюу 7.4% нь хялбаршуулах, 72 санал буюу 5.1% нь хууль тогтоомжийг сурталчлах саналыг ирүүлжээ.



Зураг 15. Байгаль орчны хууль эрхзүйн орчныг сайжруулах санал

3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдлын үнэлгээ “Муу” буюу 48.3% байна. Нийт судалгаанд оролцогсдын 47.8% нь дунд зэрэг, 28.2% нь муу, 18.4% нь маш муу, 4.6% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 16. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1087 сайжруулах санал хүсэлтээс харахад 369 санал буюу 33.9% нь хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах, 322 санал буюу 29.6% нь хууль тодорхой, тогтвортой байх, 277 санал буюу 25.5% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 94 санал буюу 8.6% нь мэдээлэл сурталчилгаа хийх саналыг ирүүлжээ.



Зураг 17. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах санал

3.7. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ОРЧИН

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн салбарын татварын орчны үнэлгээ “Дунд” буюу 53.2% байна. Нийт судалгаанд оролцогсдын 57.4% нь дунд зэрэг, 20.6% нь муу, 12.3% нь маш муу, 8.2% нь сайн, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 18. Уул уурхайн салбарын татварын орчин


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1562 сайжруулах санал хүсэлтээс харахад 282 санал буюу 18.1% нь давхардуулж авахгүй байх, 251 санал буюу 16.1% нь татварын хувь хэмжээг багасгах, 219 санал буюу 14.0% нь АМНАТ-ыг бууруулах, 198 санал буюу 12.7% нь уян хатан татварын системтэй болох, 176 санал буюу 11.3% нь татвар ногдуулах аргачлалыг сайжруулах, 133 санал буюу 8.5% нь татварын орчныг тогтвортой байлгах, 102 санал буюу 6.5% нь хуулийн заалтыг хянах, сайжруулах, ойлгомжтой болгох, 101 санал буюу 6.5% нь татварын нэгдсэн бодлогыг бий болгох, 83 санал буюу 5.3% нь хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх саналыг ирүүлжээ.



Зураг 19. Уул уурхайн салбарын татварын орчныг сайжруулах санал

3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ


Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ “Муу” буюу 48.4% байна. Нийт судалгаанд оролцогсдын 45.5% нь дунд зэрэг, 33.2% нь муу, 15.6% нь маш муу, 4.7% нь сайн, 0.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 20. Дэд бүтцийн хөгжил

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1561 сайжруулах санал хүсэлтээс харахад 316 санал буюу 20.2% нь төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх, 246 санал буюу 15.8% нь авто зам барих, засвар


үйлчилгээг сайжруулах, 234 санал буюу 15.0% нь эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, 223 санал буюу 14.3% нь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, 205 санал буюу 13.1% нь төмөр зам барих, 164 санал буюу 10.5% нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 148 санал буюу 9.5% нь боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, зохицуулалтыг сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 21. Дэд бүтцийг хөгжүүлэх санал

3.9. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхын үнэлгээ **“Дунд”** буюу 53.8% байна. Нийт судалгаанд оролцогсдын 58.5% нь дунд зэрэг, 20.8% нь муу, 10.7% нь маш муу, 8.9% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 22. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1335 сайжруулах санал хүсэлтээс харахад 333 санал буюу 24.9% нь боловсон хүчнийг сайн бэлдэх, 318 санал буюу 23.8% нь ажиллах нөхцөлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, 229 санал буюу 17.2% нь мэргэшүүлэх сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, чанаржуулах, 224 санал буюу 16.8% нь мэргэжлийн сургалт зохион байгуулах, 125 санал буюу 9.4% нь сургалтын системийг сайжруулах, 85 санал буюу 6.4% нь сайн сурталчлах саналыг ирүүлжээ.



Зураг 23. Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавхыг сайжруулах санал

3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд амьдрах орчны аюулгүй байдлын үнэлгээ “Дунд” буюу 55.1% байна. Нийт судалгаанд оролцогсдын 61.5% нь дунд зэрэг, 18.0% нь муу, 9.5% нь сайн, 9.5% нь маш муу, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 24. Амьдрах орчны аюулгүй байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1206 сайжруулах санал хүсэлтээс харахад 464 санал буюу 38.5% нь дэд бүтцийг сайжруулах, 309 санал буюу 25.6% нь агаар, хөрсний бохирдлыг үе шаттай бууруулах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, 305 санал буюу 25.3% нь хүнсний аюулгүй байдалд анхаарах, 128 санал буюу 10.6% нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх саналыг ирүүлжээ.



Зураг 25. Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал

3.11. ГАЗРЫН ХАРИЛЦАА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд газрын харилцааны зохицуулалтын байдал “Дунд” буюу 53.1% байна. Нийт судалгаанд оролцогсдын 58.7% нь дунд зэрэг, 21.7% нь муу, 11.1% нь маш муу, 7.4% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 26. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1688 сайжруулах санал хүсэлтээс харахад 286 санал буюу 16.9% нь төлөвлөлт зохион байгуулалтыг сайн хийх, 266 санал буюу 15.8% нь газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд сурталчилж таниулах, 231 санал буюу 13.7% нь газрын харилцааны байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох, 216 санал буюу 12.8% нь авлигал, хүнд суртлыг арилгах, 196 санал буюу 11.6% нь газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох, 165 санал буюу 9.8% нь байгууллага хоорондын уялдааг сайжруулах, 161 санал буюу 9.5% нь мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах, 146 санал буюу 8.6% нь шуурхай байх саналыг ирүүлжээ.



Зураг 27. Газрын харилцаа, түүний зохицуулалтыг сайжруулах санал

3.12. ТӨРӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ “Муу” буюу 49.9% байна. Нийт судалгаанд оролцогсдын 53.6% нь дунд зэрэг, 26.4% нь муу, 15.0% нь маш муу, 4.2% нь сайн, 0.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 28. Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1726 сайжруулах санал хүсэлтээс харахад 340 санал буюу 19.7% нь ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, 283 санал буюу 16.4% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 269 санал буюу 15.6% нь бодлогоо тодорхой болгох, 252 санал буюу 14.6% нь бодлого тогтвортой байх, 228 санал буюу 13.2% нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, 189 санал буюу 11.0% нь орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах, 154 санал буюу 8.9% нь урт хугацаатай, хүү багатай дэмжих зээл гаргах саналыг ирүүлжээ.



Зураг 29. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах төрийн бодлогод оруулах санал

3.13. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа “Дунд” буюу 53.6% байна. Нийт судалгаанд оролцогсдын 58.7% нь дунд зэрэг, 20.7% нь муу, 11.1% нь маш муу, 8.2% нь сайн, 1.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 30. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1737 сайжруулах санал хүсэлтээс харахад 324 санал буюу 18.7% нь цахимаар үйлчилгээ үзүүлэх, 293 санал буюу 16.9% нь хүнд суртлыг арилгах, 257 санал буюу 14.8% нь зааварчилгаа, зөвлөмж өгөх, бичиг баримтын асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх, 248 санал буюу 14.3% нь төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах, 174 санал буюу 10.0% нь нэгдмэл ойлголттой, нэгдсэн системтэй болох, 167 санал буюу 9.6% нь хууль, дүрэм, журмаа мөрдөж ажиллах, 166 санал буюу 9.6% нь төрийн оролцоог багасгах, 94 санал буюу 5.4% нь хууль журмаа сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 31. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал

3.14. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ “Дунд” буюу 52.8% байна. Нийт судалгаанд оролцогсдын 52.7% нь дунд зэрэг, 20.8% нь муу, 14.3% нь маш муу, 10.8% нь сайн, 1.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 32. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1661 сайжруулах санал хүсэлтээс харахад 329 санал буюу 19.8% нь орон нутгийн оролцоог багасгах, 310 санал буюу 18.7% нь бодлогоо зөв тодорхойлж, нэг ойлголт, хандлагаар хамтарч


ажиллах, 296 санал буюу 17.8% нь хуулиас давсан дарамт шахалтыг зогсоох, зөвхөн хуулийн хүрээнд хамтран ажиллах, 265 санал буюу 16.0% нь орон нутгийн удирдлагуудад мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгч байх, 171 санал буюу 10.3% нь авлига, хүнд суртлыг арилгах, 161 санал буюу 9.7% нь мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, 117 санал буюу 7.0% нь мэдээ, мэдээллийг сурталчилж таниулах саналыг ирүүлжээ.



Зураг 33. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал

3.15. НУТГИЙН ИРГЭД БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ “Муу” буюу 48.9% байна. Нийт судалгаанд оролцогсдын 47.0% нь дунд зэрэг, 25.9% нь муу, 19.5% нь маш муу, 6.2% нь сайн, 1.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 34. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1570 сайжруулах санал хүсэлтээс харахад 404 санал буюу 25.7% нь уул уурхайн салбарыг таниулах, сурталчлах, ойлгуулах, 305 санал буюу 19.4% нь харилцан ойлголцож, хамтран ажилладаг байх, 303 санал буюу 19.3% нь орон нутгийн эрх мэдлийг багасгах, 295 санал буюу 18.8% нь асуудлыг тодорхой болгож хуульчилж өгөх, 247 санал буюу 15.7% нь иргэд хуулиа дагаж мөрдөж ухамсарлах, хуулийн мэдлэг олгох саналыг ирүүлжээ.




Зураг 35. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал

3.16. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ “Дунд” буюу 52.8%

байна. Нийт судалгаанд оролцогсдын 57.9% нь дунд зэрэг, 21.5% нь муу, 12.0% нь маш муу, 7.1% нь сайн, 1.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 36. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдлын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1326 сайжруулах санал хүсэлтээс харахад 337 санал буюу 25.4% нь цахим болгох, 285 санал буюу 21.5% нь олон шат дамжлагыг цөөрүүлэх, 191 санал буюу 14.4% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 184 санал буюу 13.9% нь үйлчилгээг хуулийн хугацаанд хурдан шийдвэрлэх, 158 санал буюу 11.9% нь өргөдлөөр талбайг өгдөг байх, 90 санал буюу 6.8% нь хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг арилгах, 81 санал буюу 6.1% нь ил тод, шударга явуулах саналыг ирүүлжээ.



Зураг 37. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах ажиллагааг хялбаршуулах санал

3.17. ОЛОН НИЙТИЙН ЗҮГЭЭС УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДАЖ БАЙГАА ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ “Муу” буюу 47.4% байна. Нийт судалгаанд оролцогсдын 46.2% нь дунд зэрэг, 30.8% нь муу, 18.7% нь маш муу, 3.3% нь сайн, 1.0% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 38. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ


Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1128 сайжруулах санал хүсэлтээс харахад 329 санал буюу 29.2% нь нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх, 273 санал буюу 24.2% нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, 204 санал буюу 18.1% нь хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох, 196 санал буюу 17.4% нь улстөржиж олон нийтийг турхирсан худал мэдээлэл тараах зэрэгт хяналт тавих, хариуцлага тооцох, 110 санал буюу 9.8% нь нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах саналыг ирүүлжээ.



Зураг 39. Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагыг сайжруулах санал

3.18. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АВЛИГААС АНГИД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас авлигаас ангид байдлын үнэлгээ “**Муу**” буюу 51.5% байна. Нийт судалгаанд оролцогсдын 55.9% нь дунд зэрэг, 22.0% нь муу, 14.6% нь маш муу, 6.7% нь сайн, 0.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 40. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1711 сайжруулах санал хүсэлтээс харахад 302 санал буюу 17.7% нь төрийн оролцоог багасгах, 226 санал буюу 13.2% нь хүнд суртлыг арилгах, 214 санал буюу 12.5% нь шат дамжлага, зөвшөөрлийн тоог багасгах, 213 санал буюу 12.4% нь хуулийн хүрээнд ажиллах, 211 санал буюу 12.3% нь авлига авсан албан хаагчид ногдуулах арга хэмжээг чангатгах, 201 санал буюу 11.7% нь хууль эрх зүйн орчныг сайжруулах, 168 санал


буюу 9.8% нь нээлттэй ил тод болгох, 162 санал буюу 9.5% нь цахим болгох саналыг ирүүлжээ.



Зураг 41. Уул уурхайн салбарыг авлигаас ангид байлгах санал


3.19. ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ, ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ, БҮТЭЭГДЭХҮҮН, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ “Дунд” буюу 57.7% байна. Нийт судалгаанд оролцогсдын 64.5% нь дунд зэрэг, 14.7% нь сайн, 12.0% нь муу, 7.9% нь маш муу, 0.9% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 42. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарын үнэлгээ


Судалгаанд оролцогсодоос илгээсэн нийт 1368 сайжруулах санал хүсэлтээс харахад 283 санал буюу 20.7% нь чанараа сайжруулах, хариуцлагатай, хугацаандаа нийлүүлдэг байх, 276 санал буюу 20.2% нь дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, 214 санал буюу 15.6% нь хуулийн зохицуулалтыг сайжруулах, өндөр татвар, төлбөрийн дарамтыг багасгах, 199 санал буюу 14.5% нь мэргэжлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах, сургалт, 144 санал буюу 10.5% нь уялдаа холбоог сайжруулах, 125 санал буюу 9.1% нь гэрээний нөхцөлийг илүү сайн чанартай болгох, 112 санал буюу 8.2% нь мэдээллээр хангах саналыг ирүүлжээ.



Зураг 43. Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах санал


3.20. УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ “**Муу**” буюу 51.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 56.2% нь дунд зэрэг, 26.4% нь муу, 11.6% нь маш муу, 5.1% нь сайн, 0.7% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 44. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсдоос илгээсэн нийт 1323 сайжруулах санал хүсэлтээс харахад 354 санал буюу 26.8% нь ил тод, нээлттэй болгох, 273 санал буюу 20.6% нь мэдээллийг сайжруулах, 272 санал буюу 20.6% нь мэдээллийг хялбар, ойлгомжтой байдлаар нийтэд түгээх, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, 235 санал буюу 17.8% нь мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох, 175 санал буюу 13.2% нь мэдээллийн нэгдсэн сан, платформ бий болгох саналыг ирүүлжээ.



Зураг 45. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал

4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны 2023 оны байдлыг судалж үзээд дараах дүгнэлтийг гаргалаа.

- Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ **52.5** оноо буюу “**ДУНД**” гэсэн үнэлгээтэй байна.
- Үнэлгээг нэгтгэн гаргасан 20 үзүүлэлтээс “маш сайн”, “сайн” гэсэн үнэлгээ гараагүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчин таатай гэж үзэх боломжгүй байна. Мөн “маш муу” гэсэн үзүүлэлт илрээгүй нөхцөл байдал хэт хүндрээгүй байгааг илтгэж байна. Дунд ангилалд 12 үзүүлэлт, муу ангилалд 8 үзүүлэлт хамрагдав.
- Дунд ангилалд өндөр оноо авсан нь Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал /59.7 оноо/, Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал /58.4 оноо/, Ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч байгууллагуудын хүртээмжтэй байдал, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар /57.7 оноо/ байсан бол Байгаль орчны хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /56.4 оноо/, Амьдрах орчны аюулгүй байдал /55.1 оноо/, гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Ажиллах хүчний хүрэлцээ, хүний нөөцийн чадавх /53.8 оноо/, Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /53.6 оноо/ Уул уурхайн салбарын татварын орчин /53.2 оноо/, Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /53.1 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /52.8 оноо/, Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал /52.8 оноо/, Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль эрхзүйн орчны ойлгомжтой байдал /52.4 оноо/ гэсэн асуултууд нь дунд ангилалдаа доогуур жагсжээ.
- Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /45.3 оноо/ бол үүний дараа Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага /47.4 оноо/ орсон. Дараагийн түвшний тааруухан үзүүлэлт нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /48.3 оноо/, Дэд бүтцийн хөгжил /48.4 оноо/, Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /48.9 оноо/ байсан бол муу ангилал дотроо дээгүүр үзүүлэлттэй байгаа нь Төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө /49.9 оноо/, Уул уурхайн салбарт хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж /51.4 оноо/, Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал /51.5 оноо/ байв.

- Хамгийн өндөр үнэлгээтэй үзүүлэлт нь “Геологи, хайгуулын ажлын үр дүн, тэдгээрийн үнэмшилтэй байдал” байгаа хэдий ч хяналт, хариуцлагын тогтолцоо сул, мэргэжлийн байгууллага, мэргэжилтний оролцоо хангалттай бус байгаагаас дунд үнэлгээг авсан байна. Дараагийн өндөр үнэлгээтэй “Геологийн мэдээллийг олж авах боломж, мэдээллийн ил тод байдал” үзүүлэлт нь мэдээлэл бүрэн цахимжаагүй, нээлттэй байдаггүй, мэдээллийн сан, сайтын мэдээлэл шинэчлэлт бага байгаа нь дунд үнэлгээ авахад нөлөөлжээ.
- Хамгийн муу үзүүлэлт нь “Улс төрийн тогтвортой байдал” болсон шалтгаан нь, эрх зүйн орчны байдал тааруу, салбарын үйл ажиллагаа улс төр, намын үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай болж, салбарыг мэргэжлийн бус хүн удирдаж, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй, Засгийн газар, төрийн байгууллагын үйл ажиллагаа тогтвортой явагдахгүй, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт ихээр хийгдэж, улс төрчдийн хариуцлагагүй үйлдэл, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас болжээ.
- Дараагийн тааруухан үзүүлэлтэд “Олон нийтийн зүгээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага” орж байгаа нь ард иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл очихгүй, улс төрч, төрийн бус байгууллага худлаа, буруу мэдээлэл түгээж, популизм хийж байгаагийн зэрэгцээ хууль бус олборлолт, нөхөн сэргээлт хийдэггүй, хариуцлагатай уул уурхайг хангалттай хэмжээнд хөгжүүлэхгүй, салбарын хэмжээнд нэгдсэн бодлого өгүүлэгдэж байгаатай холбоотой. “Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал”-д хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах дэмжлэг сул, хууль эрх зүйн орчны тогтворгүй, тодорхой бус байдал, оролцогч талуудад мэдээлэл сурталчилгаа бага хийдэг зэрэг голлох шалтгаанууд нөлөөлсөн байна.

5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин 2023 оны байдлаар “Дунд” үнэлгээтэй болон үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь “маш сайн”, “сайн” үнэлгээнд хүрээгүй байгаа тул хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна.

- Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулж, салбарын үйл ажиллагааг нам, улс төрийн үйл ажиллагаанаас хамаарал багатай байлгахыг хичээж, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, тогтвортой ажиллуулж, Засгийн газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад анхаарч, улс төрчдийн хариуцлагыг өндөржүүлж зохицуулах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай.
- Олон нийтэд үнэн, бодит, салбарын талаар эерэг ойлголтыг өгөх мэдлэг, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгаа, PR-ийн ажлыг тогтмол зохион байгуулах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулж, улс төржиж олон нийтийг турхирсан худал мэдээлэл тараах үйл ажиллагаанд хяналт тавьж, хариуцлага тооцдог болох нь зүйтэй.
- Хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжих, ажиллах нөхцөлөөр хангах тогтолцоог хэрэгжүүлж, аливаа гэнэтийн шийдвэр гаргахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, хууль эрх зүйн орчныг тодорхой болгох, сайжруулах, оролцогч талуудыг мэдээллээр хангаж ажиллах.
- Төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөний дагуу авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төмөр зам барихад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлж дэд бүтцийн хөгжлийг сайжруулах шаардлагатай байна. Мөн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, зохицуулалтыг сайжруулж, төмөр замын ачаа эргэлтийг оновчтой зохион байгуулах хэрэгтэй байна.
- Уул уурхайн салбарын үйл ажиллагааг иргэдэд таниулах, сурталчлах, ойлгуулах, иргэдийг хуулиа дагаж мөрдөх талаар ухамсарлуулах, хууль эрх зүйн орчны талаар мэдлэг олгох, орон нутгийн эрх мэдлийг багасгаж, орон нутгийн иргэдийн уул уурхайн үйл ажиллагаанд оролцох харилцааг тодорхой болгон хуульчилж, харилцан ойлголцож хамтран ажилладаг

тогтолцоог нэвтрүүлснээр нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулна.

- Хөрөнгө оруулагчийг дэмжсэн тодорхой, тогтвортой бодлого баримталж, хууль эрх зүйн орчныг сайжруулахдаа хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, орон нутгийн эрх мэдлийг тодорхой хэмжээнд хязгаарласнаар төрөөс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөг сайжруулж болно. Мөн урт хугацаатай, бага хүүтэй зээл зэрэг санхүүгийн дэмжлэг хэрэгцээтэй байна.